



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 26

Мандалговь

**Ц.Саранчимэгийг Мал эмнэлгийн газрын
Сайхан-Овоо сумын Мал эмнэлгийн тасгийн улсын
байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Мал эмнэлгийн газрын Сайхан-Овоо сумын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Ц.Саранчимэг 48.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Ц.Саранчимэгийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны ... дугаар сарын
...-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

**Мал эмнэлгийн газрын Сайхан-Овоо сумын Мал эмнэлгийн
тасгийн улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн
Ц.Саранчимэгийн тухай дүгнэлт**

1. Ц.Саранчимэг нь 1969 онд Дундговь аймгийн Сайхан-Овоо суманд төрсөн. 53 настай, эмэгтэй
2. Ц.Саранчимэгийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мал эмнэлгийн газрын Сайхан-Овоо сумын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ